



БАЯНХОНГОР АЙМАГТ 2022 ОНЫ 05 ДУГААР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2022 оны 06 дугаар сарын 02

Номгон

НЭГ: ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

1.1. Тус цагдаагийн газар нь 2022 оны эхний 5 сард иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2200 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 525 буюу 31.3 хувиар өссөн. Үүнээс 571 буюу 25.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1629 буюу 74 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол,
мэдээллийн шийдвэрлэлт :

Зөрчлийн шинжтэй гомдол,
мэдээллийн шийдвэрлэлт:




Хүлээн авч шалагасан гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 73, зөрчлийн шинжтэй 37 нийт 110 буюу 5 хувь нь шийдвэрлэгдээгүй, хуулийн хугацаанд шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 50 буюу 8.7 хувийг 5 хоногт, 448 буюу 78.4 хувийг 6-19 хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 1561 буюу 95.8 хувийг 5 хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд энэ оны эхний 5 сард сард 202 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26 нэгжээр буюу 14.7 хувиар буурсан.



Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 98 хэрэг бүртгэгдснээс 34 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 34.7 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 11.3 пунктээр буурсан байна.


60.1% буюу **95** нь Баянхонгор сум
39.9% буюу **63** нь бусад сумдад
 Баянхонгор сум




Бусад сум



Гэмт хэргийн гаралтыг багаар нь харьцуулсан байдал




Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:


Бүртгэгдсэн гэмт хэргийн 171 буюу 84.6 хувь нь хөнгөн ангилалын, 31 буюу 15.3 хувь нь хүнд ангилалын гэмт хэрэг бүртгэгдсэн.



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/:


Хэргийн ангилал	Өссөн дүнгээр			
	2021 оны 05 сар	2022 оны 05 сар	Өөрчлөлт	
			Өөрчлөлт	Хувь
Хүнийг алах	1	1		
Хүнийг амиа хорлох нөхцөл, байдалд хүргэх	0	1	1	100%
Хүний эрүүл мэндийн халдашгүй байлын эсрэг	81	64	-17	-20.9%
Хүчиндэх	8	7	-1	-12.5%
Хулгайлах	20	29	9	45%
Мал хулгайлах	7	26	19	2.7 дахин
Дээрэм	3	1	-2	-66.6%
Залилах	14	40	26	1.8 дахин
Хүрээлэн буй орчны эсрэг	15	2	-13	-86.6%
ӨААҮАӨ	6	9	3	50%
Бусад	21	22	1	4.7%

Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл:




■ Өмчлөх эрхийн эсрэг ■ Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг ■ Бусад

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг




Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг



Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:


Бүртгэгдсэн гэмт хэргийн 60 буюу 29.7 хувь нь согтуугаар, 19 буюу 9.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 14 буюу 6.9 хувь нь бүлэглэн, 7 буюу 3.4 хувь нь хүүхэд оролцож, 19 буюу 9.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.




Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 202 гэмт хэргээс 69 буюу 34.1 хувь нь гэр орон сууцанд, 25 буюу 12.3 хувь нь гудамж талбайд, 20 буюу 9.9 хувь нь олон нийтийн газар, 9 буюу 4.4 хувь нь авто замд, 1 буюу 0.5 хувь нь төрийн байгууллага, 3 буюу 1.5 хувь нь аж ахуйн нэгжид, 79 буюу 39.1 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:




Үйлдэгдсэн цаг:



Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 205 иргэн хохирч, үүнээс 77 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 10 нэгжээр буюу 11.5 хувиар буурч, 4 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал ижил түвшинд байна.




Гэмт хэргийн улмаас 817.3 сая төгрөгийн хохирол учирснаас 207.6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 25.4 хувьтай байна.

	284.3	817.3	130.7	207.6	66.5	38.9
	1000					
	Хохирол		Нөхөн төлүүлэлт		Битүүмжилсэн хөрөнгө	
■ 2021 оны 5 сар	284.3		130.7		66.5	
■ 2022 оны 5 сар	817.3		207.6		38.9	

Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 152 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 нэгжээр буюу 5.5 хувиар өссөн бөгөөд 17 эмэгтэй хүн холбогдон шалгагдсан нь 10.5 хувиар буурч, 38 хүн урьд ял шийтгэгдсэн нь 35.7 хувиар өссөн.



Нийгмийн байдал



Боловсролоор нь



ГУРАВ: ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

Аймгийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сард нийт 6413 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 405 зөрчлөөр буюу 6.7 хувиар өссөн. Бүртгэгдсэн зөрчлийн 6335 буюу 98.8 хувийг шийдвэрлэсэн байна.

Бүртгэгдсэн зөрчлөөс 5330 зөрчлийг ердийн журмаар 130854.3 төгрөгөөр, 717 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар 177880.0 мянган төгрөгөөр, зөрчлийн хэрэг нээн шалгасан 44 зөрчлийг 10380.0 мянган төгрөгөөр /нийт торгууль 319114.3/ тус тус торгож шийдвэрлэсэн байна.

Энэ хугацаанд 238 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь 2 нэгжээр буюу - 0.8 хувиар, 314 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 54 нэгжээр буюу 20.8 хувиар өссөн байна.



Зөрчил үйлдэгдсэн онцлог:

Зөрчил үйлдэгдсэн байдал	2021.05 сар	2022.05 сар	/Өсөлт,бууралт/	Хувиар
Согтуугаар	667	775	108	16.2%
Хүүхэд оролцсон	8	6	-2	-25%
Эмэгтэй хүн оролцсон	68	161	93	1.3 дахин
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	86	119	33	38.4%
Олон нийтийн газар	46	42	-4	-8.7%
Гэр орон сууцанд	230	293	63	27.4%
Гудамж талбайд	715	635	-80	-11.2%


Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь:

Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
06-12 цагт	1492 буюу 23.2%	Даваа гараг	1071 буюу 16.7%
		Мягмар гараг	954 буюу 14.8%
13-18 цагт	3107 буюу 48.4%	Лхагва гараг	1022 буюу 15.9%
		Пүрэв гараг	834 буюу 13%

19-24 цагт	1520 буюу 23.7%	Баасан гараг	944 буюу 14.7%
		Бямба гараг	810 буюу 12.6%
01-05 цагт	294 буюу 4.6%	Ням гараг	778 буюу 12.1%

Зөрчил үйлдсэн иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл:

Энэ хугацаанд 1004 иргэн зөрчилд холбогдон шалгагдсанаас 194 буюу 19.3 хувь нь эмэгтэй, 298 буюу 29.7 хувь нь малчин болон ажилгүй, 176 буюу 17.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 79 буюу 7.8 хувь нь төрийн албан хаагч эзэлж байгаа нь бусад салбараас өндөр хувийг эзэлж байна.



Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл:




744 буюу **74** хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч

262 буюу **26** хувьд шүүгч

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагаа:

Энэ хугацаанд 462 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99 нэгжээр буюу 27.3 хувиар өсч, эрүүлжүүлэгдсэн хүний 385 буюу 83.3 хувийг гэр, орон сууцнаас, 43 буюу 9.3 хувийг гудамж талбайгаас, 16 буюу 3.4 хувийг байгууллага, аж ахуйн нэгжээс, 7 буюу 1.5 хувийг үзвэр, үйлчилгээний газраас, 2 буюу 0.4 хувийг зочид буудлаас, 6 буюу 1.3 хувийг бар цэнгээний газраас тус тус эрүүлжүүлэгдсэн байна.

Сүүлийн 5 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо:



Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 436 буюу 94.4 хувь нь эрэгтэй, 26 буюу 5.6 хувь нь эмэгтэй хүн эзэлж байна.

НЭГ: ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 5 сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

НЭГ. ХҮЛЭЭН АВСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР:

1.1. Тус цагдаагийн газарт 2022 оны эхний 5 сард иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2200 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 525 нэгжээр буюу 31.3 хувиар өссөн.

1.2 Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар нь нийт хүлээн авч шалгасан гомдол, мэдээллийн ачааллаар орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн хэмжээнд ТАВДУГААРТ хангайн бүсийн 6 аймгаас ГУРАВДУГААР эрэмбэлэгдэж байна.

ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР:

2.1. Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газарт 2022 оны эхний 5 сард нийт 202 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 нэгжээр буюу 14.7 хувиар өссөн.

2.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг Эрүүгийн хуулийн бүлгээр нь авч үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 20.9 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 66.6 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 12.5 хувиар, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 86.6 хувиар **тус тус буурч**, хулгайлах гэмт хэрэг 45 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 2.7 дахин, залилах гэмт хэрэг 1.8 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 50 хувиар **тус тус өссөн**.

2.3. Бүртгэгдсэн хэргийн 64 буюу 31.6 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 108 буюу 53.4 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эдгээр 2 бүлгийн гэмт хэрэг нь нийт хэргийн 85.1 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа үзүүлэлт юм.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 63.3 хувь нь Баянхонгор суманд үйлдэгдэж 37.6 хувиар өсч, 36.6 хувь нь бусад сумдад үйлдэгдэж 10.8 хувиар буурсан байна.

Мөн зонхилон үйлдэгддэг хулгайлах, мал хулгайлах, залилах болон бусад гэмт хэргүүд өссөн нь нийт хэрэг өсөхөд нөлөөлсөн.

2.4. Нийт гэмт хэргийн гаралтаар орон нутгийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сарын байдлаар АРВАНГУРАВДУГААРТ, хангайн бүсийн хэмжээнд ДӨРӨВДҮГЭЭРТ байна.

2.5 Мал хулгайлах гэмт хэрэг 2.7 дахин, залилах гэмт хэрэг 1.8 дахин өссөн . Тэр дундаа залилах гэмт хэрэг нь цахим орчинд үйлдэгдэх тохиолдол өссөөр байгаа нь онцгой анхаарал татаж байна.

ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ТАЛААР:

3.1. Гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 34.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.3 хувиар буурсан. Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлтээрээ орон нутгийн 29 нэгжээс 29 дүгээрт байна. Цаашид гэмт хэргийг

илрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД ХОЛБОГДОГЧИЙН ТАЛААР:

4.1. Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдийн нийгмийн байдлаар нь авч үзэхэд гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 59 буюу 38.8 хувь нь, гэмт хэрэгт өртөж хохирогчдийн 51 буюу 24.8 хувь нь, зөрчилд холбогдогчийн 298 буюу 29.7 хувь хувь нь тус тус малчин иргэд байгаа нь тэдний хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Мөн төрийн албан хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдох явдал нь таслан зогсоогдохгүй байгаа тул шийдвэрлэгдсэн тухай бүр нь байгууллагад нь “Албан мэдэгдэл” хүргүүлж, үр дүнг нь тооцож ажиллаж, сахилга ёс зүйг нь сайжруулах шаардлагатай байна.

ТАВ. ЗӨРЧЛИЙН ТАЛААР:

5.1. Аймгийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сард нийт 6413 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 405 зөрчлөөр буюу 6.7 хувиар өссөн.

Зөрчил гаргасан нийт 6091 иргэнийг **319114.3** төгрөгөөр торгосон. Үүнээс 4867 буюу 79.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчил байна.

5.2. Энэ хугацаанд 462 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99 нэгжээр буюу 27.3 хувиар өссөн. Мөн архидан согтуурч зөрчил үйлдсэн 71 иргэнийг албадан саатуулсан. Энэ хугацаанд эрүүлжүүлэгдсэн иргэдийн 385 буюу 83.3 хувь нь гэр орон сууцнаас эрүүлжүүлэгдсэн байгаа нь гэр бүл, ахуйн хүрээнд архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэх тохиолдол их байгаатай холбоотой байна.

САНАЛ

1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нэг хором” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг аймгийн ГХУСАЗСЗ болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
2. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр “Жаргалтай амьдрал” төвтэй хамтран ажиллах, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн криминологи судалгааны хүрээнд боловсруулсан зөвлөмжийг хэрэгжүүлэх,
3. Залилах болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалтууд, нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулах,
4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил удаа дараа үйлдэж буй иргэдэд чиглэсэн нэг бүрчилсэн хяналтыг хэрэгжүүлэх,
5. Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээг “Хөршийн холбоо”-ны гишүүдтэй хамтран зохион байгуулах
6. Өмчийн хулгай болон мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ноолуур” хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах,

7. Төрийн албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Албан мэдэгдэл” хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах,
8. Урин дулаан цаг ирж байгаатай холбогдуулан үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран эргүүл, хяналтыг тогтмол зохион байгуулж ажиллах,
9. Гэмт хэргийн гаралт өсөлттэй байгаа баг, сумдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөө сумдын иргэд, малчдыг мэдээллээр хангах, тэдэнд хууль, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор сумдад урьдчилан сэргийлэх ажил, сургалт, сурталчилгааг зохион байгуулах,

ТАНИЛЦУУЛГА ГАРГАСАН:

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Б.БЯМБАА

ТАНИЛЦСАН:

ДЭД БӨГӨӨД ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Д.БАТЗАЯА